



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2016 оны 08 сарын 16 өдөр

Дугаар 8/08

Улаанбаатар хот

Г

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2, 14.2.3, 14.2.5 дах заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн салбарт тулгамдаж буй зорилтыг яаралтай шийдвэрлэх зорилгоор 2016 оны төсөвт тусгагдсан хөрөнгийг дараах хөтөлбөр арга хэмжээнд зарцуулахаар хуваарилсугай.

А. Хавдар судлалын үндэсний төвийн эмнэлгийн өргөтгөлийн хэсэг ашиглалтад орсонтой холбогдуулан гарах урсгал зардалд 700,000,000.00 /долоон зуун сая/ төгрөг,

Б. Засгийн газрын 323 дугаар тогтоолын дагуу Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн барилгад Улсын нэгдүгээр эмнэлгийн салбар амбулатори ажиллаж байгаатай холбогдуулан үйл ажиллагаа эхлүүлэх зардалд 504,028,630.00 /таван зуун дөрвөн сая хорин найман мянга зургаан зуун гучин/ төгрөг,

2. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газрын дарга /С.Төгсдэлгэр/, Санхүү, эдийн засгийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Т.Баярсайхан/ нарт үүрэг болгосугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэнд, спортын сайдын 2016 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн "Хөрөнгө зарцуулах тухай" А/203 дугаар тушаалын А. Эрүүл мэндийн салбарт 4, 5, 6, 7, 8, 9, 10 заалт, Б. Биеийн тамир, спортын салбарт 3, 4 заалт В. Бусад зардлын 1 дэх заалтуудыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



А.ЦОГЦЭЦЭГ

A/304 тог тушаалы
БЗ.Б4 хүчинчлэл 080032